



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ



МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:



Санамж:

- ✓ Монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын 20 даалгаврыг 40 минутад гүйцэтгэх тул цагаа сайтар төлөвлөж бүх даалгаврыг ажиллаарай.
- ✓ Монгол хэлний даалгавруудыг гүйцэтгэхдээ эхийг уншиж, сайтар ойлгосон байхыг анхаараарай.

Өнчин хусны дууль

Халцгай хөх уулын суга, гүн жалганы эхэнд өнчин хус цайрна. Харваас гуниглангуй бөхөлзөж хааяа нэг алтан навч хаялах нь хаа эртний нэгэн уйтай явдлыг дурсан санах билээ.

Тээр жил энэ нутагт тэнгэр улайсам ган болжээ. Хатаж хорчийсон навчсаа бүүвэйлэн суусан төгөл хусны хамгийн захад ургасан өндөр гоолиг нэгэн хусанд тэнүүлч салхи бялдуучлан

- Чамд л гэж нууцаа дэлгэхэд цангаж суух учиргүй байна. Алсад хөхрөх тэртээ уулын энгэрт ашид ширгэшгүй нэгэн булаг байна хэмээн шивнэжээ.

Салхины үгийг сонсоод хус мод саргүй гүн шөнөөр үндэс юугаа булга татан ойгоо орхиод үеийн нөхдөдөө дуулгалгүй тэр булгийг зорьжээ. Асга хад дамжин үүр цайтал яваад арай гэж зорьсон газраа хүрвэл сэрүү татсан хүйтэн булаг мэлтрэн урсаж, мандаж буй нарны алтан цацрагийг мандалдаа булхуулж байв.

Тэсгэл алдсан хус үндэс мөчрөө алдлан тэлж, тэрхэн зуур ус залгилахаар тонгойтол, агшин төдийд булаг урсгалаа татаж:

- Ганц биеийн жаргалыг бодож газрын холоос чи ирлээ.
Гандаж цөхөрсөн нөхдөдөө дуулгаад олуулаа ирсэн бол
Ариун усаа би та нарт юүлж
Асга хадыг бүрхтэл ургуулах байсан
Аминчхан чамд бол амсуулах ч үгүй гэлээ.

Тэнгэр газрыг аргадан уйлавч булгийн ус ундарсангүй. Тэргэл цагаан хус буруугаа ойлгож, гэмшивч тэнхээ тамир нь сульдаад тэртээ алс хоцорсон нөхдөдөө эргэн очиж чадсангүй.

Ийнхүү цөхрөөд гурав хонож байтал гэнэт их хур бууж, нутаг даяар ган тайлагдлаа. Хур нар тэгширсэн сайхан цаг ирэвч хөөрхий хус буйд энэ газар өнчин ганцаар үлджээ.

О.Сундуй “Тэнгэрт өлгөөтэй бяслаг, 32-р тал”

Монгол хэлний даалгаврууд

1. Эхэд юуны тухай өгүүлж байна вэ?
 - A. Бялдууч салхины тухай
 - B. Хус модны аялсан тухай
 - C. Ган тайлагдсан тухай
 - D. Хувиа бодсон зангийн тухай

2. Эхийн өрнөсөн үйл явдлыг цаг хугацааны дарааллаар эрэмбэлээрэй.
 1. Тэнүүлч салхи бялдуучлан шивнэжээ.
 2. Асга хад дамжин үүр цайтал яваад арай гэж зорьсон газраа хүрлээ.
 3. Тээр жил энэ нутагт тэнгэр улайсам ган болжээ.
 4. Хөөрхий хус буйд энэ газар өнчин ганцаар үлджээ.

A. 1, 2, 4, 3 B. 3, 1, 2, 4 C. 4, 1, 2, 3 D. 1, 3, 2, 4




3. Дараах өгүүлбэрүүдээс эхийн гол санааг илэрхийлснийг олоорой?
- A. Тэргэл цагаан хус буруугаа ойлгож, гэмшивч тэнхээ тамир нь сульдаад тэртээ алс хоцорсон нөхдөдөө эргэн очиж чадсангүй.
 - B. Салхины үгийг сонсоод хус мод саргүй гүн шөнөөр үндэс юугаа булга татан ойгоо орхиод үеийн нөхдөдөө дуулгалгүй тэр булгийг зорьжээ.
 - C. Харваас гуниглангүй бөхөлзөж хааяа нэг алтан навч хаялах нь хаа эртний нэгэн уйтай явдлыг дурсан санах билээ.
 - D. Хур нар тэгширсэн сайхан цаг ирэвч хөөрхий хус буйд энэ газар өнчин ганцаар үлджээ.
4. Сайхан зун цагийг илтгэх баримтыг олоорой.
- A. Хур нар тэгширсэн сайхан цаг ирлээ.
 - B. Ийнхүү цөхрөөд гурав хонож байтал гэнэт их хур буулаа.
 - C. Тэнгэр газрыг аргадан уйлавч булгийн ус ундарсангүй.
 - D. Сэрүү татсан хүйтэн булаг мэлтрэн урсаж байлаа.
5. Булаг хус модонд ихэд дургүйцсэн өнгө аясыг илэрхийлсэн өгүүлбэр аль нь вэ?
- A. Ганц биеийн жаргалыг бодож газрын холоос чи ирлээ.
 - B. Чамд л гэж нууцаа дэлгэхэд цангаж суух учиргүй байна.
 - C. Ариун усаа би та нарт юүлж, Асга хадыг бүрхтэл ургуулах байсан
 - D. Аминчхан чамд бол амсуулах ч үгүй гэлээ.
6. Тэнүүлч салхи: “Чамд л гэж нууцаа дэлгэхэд цангаж суух учиргүй байна. Алсад хөхрөх тэртээ уулын энгэрт ашид ширгэшгүй нэгэн булаг байна” гэж шивнэсэн. Хэрэв чи хус мод байсан бол ямар үйлдэл хийх байсан бэ?
- A. Ганц биеийн жаргалыг бодож, газрын хол руу явна.
 - B. Гандаж цөхөрсөн нөхдөдөө дуулгаад цуг явна.
 - C. Газрын хол руу явж, гандаж цөхөрсөн нөхдөдөө ус авч ирнэ.
 - D. Газрын хол руу явах чадал байхгүй тул үлдэнэ.
7. Тэнүүлч салхи: “Чамд л гэж нууцаа дэлгэхэд цангаж суух учиргүй байна. **Алсад хөхрөх тэртээ уулын энгэрт ашид ширгэшгүй нэгэн булаг байна**” гэж шивнэсэн. Хэрэв чи хус мод байсан бол юу гэж лавшруулан асуух байсан бэ?
- A. Ширгэшгүй юм бол шивнэж хэлсний учир юу вэ?
 - B. Ямар сайхан мэдээ вэ? Яг одоохон явах минь.
 - C. Заа, хө гялайлаа. Заавал тийшээ явъя.
 - D. Надаас өөр хүнд хэлээгүй биз дээ?
8. Хэрвээ хус мод нөхдөдөө хэлээд, бүгдийг нь дагуулан явсан бол булаг түүнд юу гэж хэлэх байсан бол?
- A. Ямар олуулаа ирдэг юм бэ?
 - B. Хус минь чиний сайхан сэтгэл ойг аварлаа.
 - C. “Чи хус модонд баярлалаа” гэж хэлээрэй.
 - D. “Та нар хус модонд баярлалаа” гэж хэлээрэй
9. Дараах цаг хугацаа заасан үгсээс тодорхой хугацааг заасан үгийг олоорой.
- A. хааяа нэг
 - B. хаа эртний
 - C. гурав хоног
 - D. үүр цайтал




10. “Хөөрхий хус буйд энэ газар өнчин ганцаар үлджээ.” гэсэн өгүүлбэрийн цөм бүтцийг тодорхойлоорой.

- A. Хус үлджээ.
- B. Хус өнчин үлджээ.
- C. Хус ганцаар үлджээ.
- D. Ганцаар үлджээ.


Үндэсний бичгийн даалгаврууд



11. “  ” холбоо үгийг зөв уншаарай.


- A. Зах зээл
- B. Загал зэгэл
- C. Зах эхэл
- D. Заг аа зэх

12. “  ” өгүүлбэрийг зөв хөрвүүлснийг олоорой.

- A. Танан эрдэнийн мал сүрэг.
- B. Танан эрдэнийн мал сөрөг.
- C. Таван эрдэнийн мал сүрэг.
- D. Таван эрэнийн мал сүрэг.

13. “  ” гэдэг үгэнд олон тооны тохирох дагаврыг сонгоорой.

- | | | | |
|---|--|---|---|
| A. | B. | C. | D. |
|  |  |  |  |

14. “  ” цэгийн оронд харьяалахын тийн ялгалын нөхцөлийн тохирохыг сонгоорой.

- | | | | |
|--|---|--|--|
| A. | B. | C. | D. |
|  |  |  |  |

15. “  ” гэх үгэнд эзэнд хамаатуулах нөхцөлийн зөвийг залгаарай.

- | | | | |
|---|--|---|---|
| A. | B. | C. | D. |
|  |  |  |  |



Уран зохиолын даалгаврууд

16. Л.Түдэв “Хорвоотой танилцсан түүх” туужийн доорх хэсгийг уншаад, монгол үндэстний соёлын ямар зүйлс илэрч байгааг зөв олоорой.

“... Цорын ганц боломжийн мод гэвэл өрөм хатаадаг тос нэвчсэн бор мод эргүүл дээр байв. Хэсэг эргэлзсэний эцэст би тэр модыг олзлон авч, тулганы захаас аргалын цагаан үнс хайж олоод дээр нь нунтаглан түрхэв.”

- A. өрөм хатаадаг мод, эргүүл, тулга, аргал
- B. эргүүл, тулга, мод, аргал, тос, өрөм
- C. өрөм хатаадаг мод, ганц, эргүүл, тулга
- D. эргүүл, үнс, цор ганц, цагаан, тос

17. П.Бадарчийн “Есөн эрдэнийн орон” шүлгийн “Эрхэм алдраа бадруулсан өнөр өөдрөг тмэн Эрэлхэг монгол ардын эв нь ган билээ.” хэмээх тодруулсан хэсэгт юуг юутай, ямар шинжээр нь адилтган бичсэн байна вэ?

- A. Эвийг ган эрдэнэтэй бат бөх шинжээр нь адилтгасан
- B. Ган эрдэнийг эвийн бат бөхтэй шинжээр нь адилтгасан
- C. Ган эрдэнийг эвийн өнгөөр нь адилтгасан
- D. Эвийг ган эрдэнэтэй өнгөөр нь адилтгасан

18. Үйл явдал нь ууланд өрнөдөг зохиол аль вэ?

- A. “Шударга шүүгч” Л.Толстой
- B. “Цаасан онгоцны” үлгэр Кейко Тани
- C. “Алт, мөнгө хоёр” П.Хорлоо
- D. “Тосгоны овгор” Оскар Уайлд

19. Зохиолч Л.Одончимэд “Хүүхдийн бор” өгүүллэгт “... Бор атыг маань нэгдэлд авна гэж зүтгэсэн “Нийбүү”, эцэж туртал нь эдэлсэн Гонгор гуай хоёрт би том болтлоо үнэн голоосоо гомдон явж билээ.” гэсэн хэсэг бий. Энэхүү хэсгээс бор атныхаа тухай дурсан санаж буй хүүгийн зан чанарыг тодорхойлоорой.

- A. Энэрэнгүй зөөлөн
- B. Алсын бодолтой
- C. Хатуу чанга
- D. Амиа хоохойлсон

20. Дараах шүлгийн хэсгүүдээс урнаар давтаж бичсэнийг сонгоорой.

Хөрст дэлхий
Хөлийн доор
Хөлийн доор

- A. AABV - хос холбоц
- B. ABAB - салаалсан холбоц
- C. AAAA - бүрэн холбоц
- D. ABBA - хашсан холбоц

